



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/62

Хэрлэн сум

**Үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Нэгдсэн Үндэсний Байгууллагын “Хүүхдийн сан”-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу хэрэгжүүлж буй Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг “Нүүрсгүй шийдэл - Монгол гэрийн халаалт, дулаалга, агаар сэлгэлтийн СИР/ЧИП багцыг нэвтрүүлэх” төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд 16,792,000 (арван зургаан сая долоон зуун ерэн хоёр мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт дансанд байршуулсан “Хүүхдийн сан”-ийн санхүүжилтээс зарцуулахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын  
2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн  
1162 дугаар тушаалын хавсралт

“ЧИП багцыг нэвтрүүлэх” төслийн үйл ажиллагааны зардал

№	Үйл ажиллагаа	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ ₮	Нийт үнэ ₮
1	Хэрлэн сум (Чингис хот)-ын 1-6-р багийн иргэдэд Чип төслийн сургалт зохион байгуулах	Төслийн танилцуулга брошур	ш	2,000	800	1,600,000
		Бизнес карт танилцуулга	ш	2,000	400	800,000
		Чип багцын гарын авлага	ш	100	8,000	800,000
		Цайны завсарлага	ш	6*50	8,000	2,400,000
2	Төсөлд хамрагдсан өрхүүдээс ярилцлага нэвтрүүлэг бэлтгэж төслийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах	Ярилцлага нэвтрүүлэг	ш	3	3,500,000	3,500,000
		Шторк	ш	3		
		Сонингийн нийтлэл	ш	3	300,000	900,000
3	Төслийн хэрэгжилтэд хяналт мониторинг хийх	Шатахуун	л	100	2,520	252,000
4	Төслийн сурталчилгааны гэр мэдээллийн төв ажиллуулах	Мэдээллийн төвд цай, бичиг хэргийн материал	ш	2	250,000	500,000
		Хаягжуулалт /байршлын болон гэрийн гадна, дотор баннер/	ш	3	100,000	300,000
5	Орон нутгийн жижиг дунд бизнес эхлэгчид, оёдолчид, үйлдвэрлэгчдэд сургалт зохион байгуулах	Чип багцын үйлдвэрлэлийн технологийн зааварчилгаа гарын авлага хэвлүүлэх	ш	45	8,000	360,000
		Цайны завсарлага	ш	30	10,000	300,000
		Бичиг хэргийн зардал	ш	30	10,000	300,000
6	Аймгийн “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицох үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулах сургалт	Цайны завсарлага	ш	4*25	10,000	1,000,000
		Өдрийн хоол	ш	2*25	40,000	2,000,000
		Бичиг хэргийн зардал	ш	2*25	10,000	500,000
		Заалны түрээс	цаг	2*8	80,000	1,280,000
<b>Нийт дүн:</b>						<b>16,792,000</b>